Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2022.06.06

Олон улсын хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтийг үзүүлэв. Үүнд, АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

АНУ-ын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	$32,899.70	$33,212.96	-0.94%	$32,997.97	-0.30%	$34,756.39	-5.34%
S&P 500	$4,108.54	$4,158.24	-1.20%	$4,146.87	-0.92%	$4,229.89	-2.87%
Nasdaq	$12,012.73	$12,131.13	-0.98%	$12,317.69	-2.48%	$13,814.49	-13.04%

Европын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,460.09	€ 14,462.19	-0.01%	€ 13,902.52	4.01%	€ 15,632.67	-7.50%
FTSE 100	£7,532.95	£7,521.13	0.16%	£7,531.14	0.02%	£7,080.50	6.39%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,089.57	¥4,001.30	2.21%	¥4,010.21	1.98%	¥5,289.97	-22.69%
Hang Seng	HKD 21,082.13	HKD 20,697.36	1.86%	HKD 21,905.29	-3.76%	HKD 28,918.10	-27.10%
Nikkei 225	JPY 27,761.57	JPY 26,781.68	3.66%	JPY 27,003.56	2.81%	JPY 28,941.52	-4.08%



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Энэ 7 хоногт анхааралтай ажиглах таван үйл явдал

1. АНУ-ын хэрэглээний үнийн индекс өсөх үү?

АНУ-ын 5 сарын хэрэглээний үнийн индекс баасан гарагт зарлагдана. Энэхүү тоон мэдээлэлд тулгуурлаж Холбооны Нөөцийн Сан (ХНС) бодлогын хүүг хэдээр нэмэхээ шийдэх юм.

Шинжээчид тавдугаар сарын инцляцийг жилийн өмнөхтэй харвцуулбал 8.3 хувьтай гарна гэж таамаглаж байна. Харин үндсэн инфляци буюу савлагаатай бүтээгдэхүүний үнийг хассаны дараах инфляцийг 5.9 хувь байна гэж үзэж байна.

Хэрэв судлаачдын таамаглалаар гарвал инфляцийг аль хэдийн оройн цэгтээ хүрсэн гэж үзэж болох бөгөөд буурах төлөв руу шилжиж байна гэж дүгнэж болох юм.

2. Европын Төв банк бодлогын хүүгээ өсгөх үү?

Европт инфляци өсөж байгаа нь Төв Банкны санааг ихээр зовоож байна. Тиймээс тус банкнаас 6 сарын 9-нд мөнгөний бодлогын хүүг өсгөх эсэх талаар хэвлэлийн бага хурал хийнэ гэж мэдэгдээд байна.

3. Газрын тосны нийлүүлэлт эрэлтээ хангаж чадах уу?

Газрын тос экспортлогч орнуудын нэгдсэн байгууллага болох OPEC нь газрын тосны гарцаа 50 хувиар өсгөнө гэж зарласан. Гэхдээ эрэлт өсөж буй үед энэхүү нийлүүлэлт хангалттай эсэх нь эргэлзээтэй байгаа юм.

Өнгөрсөн баасан гарагт West Texas Intermediate Futures болох стандарт газрын тосны фьючерс нь 2.9 хувиар өсөж 120.26 ам.долларт хүрсэн. Харин Брент нефтийн фьючерс 2.95 хувиар өсөж 121.08 ам.долларт хүрсэн.

Иргэдийн зуны аялал зугаалга эхэлж байгаа нь нефтийн эрэлтийг өсгөж, ханшид нөлөөлөхөөр байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

4. Энэ 7 хоногт санхүүгийн тайлангаа тавих компаниуд

Ихэнх компани нэгдүгээр улирлын санхүүгийн тайлангаа танилцуулсан. Гэхдээ энэ долоо хоногт зарим томоохон компани тайлангаа тавихаар хүлээгдэж байна.

Тодруулбал, Coupa Software Inc, Smartsheet, DocuSign зэрэг програм хангамжийн компаниуд болон NIO, SAIC зэрэг автомашин үйлдвэрлэгч салбарын компаниуд тайлангаа тавих юм.

Хөрөнгө оруулагчид энэхүү мэдээлэлд тулгуурлаж өөрсдийн хөрөнгө оруулалтын багцаа шинэчлэх болно.

5. Компаниуд эдийн засаг хүндрэнэ гэсэн хүлээлтэй байна уу?

Өнгөрсөн 7 хоногт JPMorgan-аас эдийн засгийн нөхцөл байдал хүндрэнэ, Elon Musk нийт ажилчдынхаа 10 хувийг цомхотгоно, Coinbase нэмж ажилтан авахгүй гэж мэдэгдсэн нь хөрөнгө оруулагчдын санааг зовоож байна.

Энэ 7 хоногт зарим хөрөнгө оруулагчид хэвлэлийн бага хурал хийх мэдээлэл байгаа бөгөөд энэ нь эдийн засаг хямралын ирмэг дээр байгаа эсэхийг дүгнэхэд дөхөм болно.

ЖОЕ БАЙДЕН САУДЫН АРАБ РУУ АЙЛЧИЛНА

Өнгөрсөн баасан гарагт АНУ-ын ерөнхийлөгч Жое Байден Саудын Араб руу айлчлах бодолтой байна гэдгээ мэдэгдсэн.

Саудын Араб нь АНУ-ын өсөж буй инфляцийг бууруулахад тусалж газрын тосны гарцаа өсгөх ба дайнд нэрвэгдсэн Йемен улсад энх тайван тогтооход туслана гэж мэдэгдсэн.

Тиймээс ерөнхийлөгч Жое Байден Саудын Арабын ханхүү Мохаммед Бен Салмантай уулзах бодолтой байгаагаа мэдэгдсэн ч эцсийн шийдвэр хараахан гараагүй байна.

Хэрэв энэхүү уулзалт болвол АНУ болон Саудын Араб дэлхийн энх тайван, хүний эрх, газрын тос зэрэг асуудлуудыг хэлэлцэх төлөвтэй байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.